



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас: (976) 7032 2073,

Цахим шуудан: [uvurkhangaï@gov.mn](mailto:uvurkhangaï@gov.mn)


Цахим хуудас: [www.uvurkhangaï.mn](http://www.uvurkhangaï.mn)

2022. 04. 26 № 3-4/2022  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

### СУМЫН ЗАСАГ ДАРГА, ГАЗАР, ХЭЛТЭС, АЛБАДЫН ДАРГА НАРТ


Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр тус хэлтсээс санаачлан “Авлигын эсрэг миний-бидний оролцоо” сэдэвт 45 хоногийн аян зохион байгуулахаар удирдамж боловсруулан, батлуулж хүргүүлээд байна.

Иймд сум, байгууллагынхаа түвшинд удирдамжид заасан 9 ажил, арга хэмжээгээр хязгаарлалгүйгээр өөр бусад шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулан, хэрэгжилтийг хавсралт хүснэгтээр 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст цахим [mnhcecegd@gmail.com](mailto:mnhcecegd@gmail.com) хаяг болон цаасан хэлбэрээр нотлох баримтын хамт ирүүлнэ үү. Лавлах утас: 70323087

Хавсралт  хуудастай.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН  
ДАРГА

А.ОТГОНЦЭЦЭГ



6222 33 0432



БАТЛАВ  
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

2022 оны 04 дугаар сарын 26

УДИРДАМЖ

2022 оны 04 дугаар сарын 26

Арвайхээр

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх "Авлигын эсрэг миний-бидний оролцоо" сэдэвт 45 хоногийн аяны тухай

Нэг. Аяны зорилго

Аймаг, орон нутгийн хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулан, авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр дүнтэй тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлэх, төрийн байгууллага, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газар (Хууль, эрх зүйн хэлтэс), 19 сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 22 агентлаг, бусад төрийн байгууллагууд оролцоно.

Гурав. Хугацаа

2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хэрэгжинэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээ

4.1.Аймгийн Засаг даргын Тамгын газар, Авлигатай тэмцэх газраас санаачлан гаргасан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.

4.2.Авлигын эсрэг үйл ажиллагаанд төрийн байгууллагын удирдлагын манлайллыг хэрэгжүүлж, аяны хүрээнд тодорхой төсөв мөнгө шийдвэрлэн, зарцуулах.

4.3.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр "Аймгийн Засаг даргын Тамгын газар (Хууль, эрх зүйн хэлтэс) цахим хуудас болон Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн нэр бүхий 2 цахим хуудсын хандалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг сум, байгууллагын түвшинд зохион байгуулах.

4.4.Төрийн албан хаагч, хүүхэд залуучууд, иргэд олон нийтэд хандсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт, өдөрлөг, уулзалт зэрэг нөлөөллийн бусад арга хэмжээ зохион байгуулах.

4.5.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх зэрэг төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлэх.

4.6. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.

4.7. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах.

4.8. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээлүүлэх чиглэлээр хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах.

4.9. Сум, агентлагууд аяны хугацаанд үр дүнтэй тодорхой ажлуудыг зохион байгуулж, хийгдсэн ажлаа байгууллагынхаа албан ёсны цахим хуудас болон "Аймгийн Засаг даргын Тамгын газар (Хууль, эрх зүйн хэлтэс)" цахим хуудсуудад тухай бүр байршуулж сурталчлах.

Тав. Аяны үйл ажиллагааг дүгнэх

Аяны үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор явцын болон гүйцэтгэлийн үр дүнгээр үнэлнэ. Явцын үйл ажиллагааг сум, байгууллагын албан ёсны цахим хуудсанд (аяны хугацаанд долоо хоног бүрийн баасан гарагт) нэвтрэн үнэлэлт өгөх, гүйцэтгэлийн үнэлгээг ирүүлсэн тайлан, мэдээ (нотлох баримтаар) мөн аяны дуусгавар болох хугацаа буюу 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр цахимаар үнэлнэ.

Сум, агентлагуудын 45 хоногийн аяны үйл ажиллагааг дүгнэхдээ удирдамжид заагдсан 9 ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан байдал, төсөв хөрөнгө зарцуулсан байдал, тайлан мэдээг нотлох баримтаар ирүүлсэн байдал, аймгийн болон Авлигатай тэмцэх газрын цахим хуудсын хандалтыг нэмэгдүүлсэн байдал, шинийг санаачлан хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ зэргийг харгалзан идэвхтэй оролцсон 3 хүртэл сум, байгууллага, эрх бүхий албан тушаалтныг шагнаж, урамшуулна.